



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 26 өдөр

Дугаар АЧН

Улаанбаатар хот

Ахмадын сан байгуулах тухай

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, төвийн Хамтын гэрээний 7.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвд ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад настнуудын нийгмийн хамгааллын асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Төвийн ахмадын сан” байгуулж, төсөвт багтаан санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Ө.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

2. Ахмадын сангийн зарцуулалтын тайланг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор багтаан төвийн Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Хүний нөөцийн ажилтан /Б.Амаржаргал/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /Д.Амар/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР